



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 359

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цаг уур, орчны шинжилгээний газар түүний харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 136,003,010.20 (нэг зуун гучин зургаан сая гурван мянга арван төгрөг хорин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 10 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, аймгуудын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтын хамт 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

300635

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн
359 дугаар тогтоолын хавсралт

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХАРЬАА БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын нийт үнэ, /хуримтлагдсан элэгдэл/ төгрөг	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1.Архангай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв						
1	УАЗ-31512 суудлын, 49-00 АРА, арал 70565297, хөдөлгүүр 60014748	2007/2007	215000	13,431,000.00	-	1,000,000.00
	Дүн			13,431,000.00		1,000,000.00
2.Баян-Өлгий аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв						
2	УАЗ-469 суудлын, 49-21 БӨА, арал 20147317, хөдөлгүүр 20087578	2002/2002	260000	9,949,500.00	-	800,000.00
	Дүн			9,949,500.00		800,000.00
3.Баянхонгор аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв						
	УАЗ-469 суудлын, 76-05 БНА, арал 70587116, хөдөлгүүр 70006786	2007/2007	117571	16,361,400.00	-	800,000.00
4	УАЗ 322069-033 микробус, 79-05 БНА, арал 80452751, хөдөлгүүр 71200136	2008/2008	186231	14,600,000.00	-	1,000,000.00
	Дүн			30,961,400.00		1,800,000.00
4. Говь-Алтай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв						
5	УАЗ-469 суудлын, 61-81 ГАА, арал 70564748, хөдөлгүүр 60014322	2007/2007	121902	13,431,000.00	-	800,000.00
	Дүн			13,431,000.00		800,000.00
5.Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв						
6	Исүзү бигхорн, суудлын, 91-85 ДОА, арлын дугаар UBS 73 GW 7200202/	1999/1999	160000	15,900,000.00		1,000,000.00
7	УАЗ-469 Суудлын, 69-80 ДОА, /модель 31512, хөдөлгүүрийн багтаамж В-2445, хөдөлгүүрийн №60013927, арал № 70563702	2007/2007	160000	13,431,000.00		800,000.00
	Дүн			29,331,000.00		1,800,000.00
6.Өмнөговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв						
	Марк- УАЗ 469, Улсын дугаар- 6112 ӨМА, зориулалт- суудал, арал - 70564612, хөдөлгүүр- 60014556	2007/2007	279582	13,431,000.00		800,000.00
	Дүн			13,431,000.00		800,000.00
7.Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв						
9	УАЗ-Фургон, суудлын, 61-34 СБТ, арал 34410020139213, хөдөлгүүр В-2476	2002/2002	129592	10,868,110.20		1,000,000.00
	Дүн			10,868,110.20		1,000,000.00
8.Хэнтий аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв						
10	УАЗ-220692-033 Фургон, 56-27 ХЭА, суудлын, хөдөлгүүр-D 2890, арал-80452801	2008/2009	217356	14,600,000.00		1,000,000.00
	Дүн			14,600,000.00		1,000,000.00
				136,003,010.20		9,000,000.00
	НИЙТ ДҮН			(нэг зуун гучин зургаан сая гурван мянга арван төгрөг хорин мөнгө)		(есөн сая)